

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
РЭНЦЭН ОВОГТОЙ ЦЭРЭНДОРЖИЙН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: "Эко-Эрдэнэт- Ирээдүйн хөгжил"

Энэхүү мөрийн хөтөлбөр нь аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль болон бусад хуулийн хүрээнд боловсруулагдсан болно.
Мөрийн хөтөлбөр нь 2 хэсгээс бүрдэнэ.

Нэг. Гэрийн хороолол

1. Урьд нь гэр хороололд хэрэгжсэн МОН-2301 төслийг үргэлжлүүлэн айл өрхүүдийг цэвэр ус бохирын шугаманд холбох ажлыг хийх асуудлыг аймаг хотын болон услын төсөвт тусгуулан шийдвэрлэх, /Цагаанчулут, Уртын гол, Рашиант Наан, Булаг, Дэнж багт хийх боломжтой/
2. Айл бүр хашаандaa мод тарих хөдөлгөөн өрнүүлэх, жимсний мод тарих сургалт-сурталчилгээ тогтмол хийх /Уртын гол багаас эхлэхэд тохиромжтой гэж үзэж байна/. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтын ажиллагааны хүрээнд дэмжлэг үзүүлэх ажиллана.
3. Хогийн менежментийг боловсронгуй болгож хог хаядаг биш хогоо цуглувалдаг, ангилан ялгадаг арга барилд сургаж хүмүүсийн сэтгэлгээ, хандлагыг өөрчлөх.
4. Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор утаа бага гаргаж бүрэн шатдаг шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.
5. Хөрс, усны бохирдлыг бууруулахын тулд "Жорлонгоо өөрчилье" сургалт, сурталчилгааг эрчимтэй хийж, "Эко-00"-той, соруулдаг 00-той болгох ажлыг дэмжин ажиллана. /Хамгийн их үерийн усанд өрдөг Уртын гол багаас эхлэх/



6. Алслагдсан гэрийн хороололд бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулах зарчмаар сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хүртээмжийг нэмэгдүүлж цэцэрлэгт хамрагдалтыг аль болох гэрт нь ойр баг хороонд нь хамруулдаг болгох.
7. Айл бүр хүнсний ногоогоо тарьж өөрсдийн өрхийн хэрэгцээг хангадаг болгох. Зоорьтой болгох, Хятадын химиин бордоотой ногоо хэрэглэхгүй байх талаар ухуулах.


Хоёр: Байшин хороолол /Город/

1. “Эко-Эрдэнэт-Ирээдүйн хөгжил” уриалгыг гаргаж хотоо ногооруулах, “Хот ногоон байгууламжийн газрын материаллаг баазыг бэхжүүлж ажиллах” дэд хөтөлбөр гарган ажиллана.
2. Жимсний цэцэрлэгтэй хот болгох хөдөлгөөн өрнүүлэх, айл өрх, албан байгууллагад сургалт, сурталчилгаа явуулах, сэтгэлгээ, хандлагыг өөрчлөх.
3. Орцонд хог хаядаг асуудлыг болиулах, хогийн менементийг боловсронгуй болгох, АЦ-ын тухай хууль, Зөрчлийн тухай асуудлаар хариуцлага тооцдог болгох, иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах талаар баг, хороотой хамтран ажиллах
4. Хотын газар төлөвлөлт, газар зохион байгуулалтыг боловсронгуй болгох. Эрдэнэт хотыг хэд хэдэн /дүүрэг/ хороотой болгож засаг захиргааны өөрчлөлтийг хуулийн дагуу өөрчлөх.
5. Эрдэнэт хотыг дугуйн замтай болгож дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх.
6. Эрдэнэт хотыг авто замыг осолгүй, аюулгүй хот болгохын тулд хот, хороолол доторх хурдны хязгаар тогтоох, дүрмээр явдаг болгох.
7. Явган хүний гарц, гэрэл дохиог стандартын шаардлага хангасан иргэд, жолооч нарт ойлгомжтой болгон өөрчлөх, хайс хашлага хамгаалалт хийх.



8. Сургуулийн бага анги, цэцэрлэгийн насын хүүхдэд замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг зааж сургах дэд хөтөлбөр сургалт зохион байгуулах, орчин бүдүүлэх.
9. Өсвөр залуу үеийг техник, технологи, программ хангамжийн мэргэжилтэй болгоход туслах зорилгоор иргэд, ААН, ТББ-ын гаргасан санаа санаачлагыг дэмжин ажиллах.
10. ШУ Технологийн паркийн судалгааны үр дүнгээр гарсан инноваци, шинэ технологийг нэвтрүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжих.
11. ЖДУ-ийн зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгуулах замаар эцсийн бүтээгдэхүүн, экспортын бүтээгдэхүүн, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжиж “Эрдэнэт брэнд” бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ.
12. Хүүхэд залуучуудын цахим хэрэглээг багасгах, гар утасны донтолтоос хамгаалах зорилгоор номын сангийн хуртээмжийг нэмэгдүүлж хувийн номын сан байгуулж ажиллуулахыг бүх талаараа дэмжих.
13. Гэр хороололд спорт цогцолбор заал байгуулах, иргэд ААН-ийн санал санаачлагыг дэмжиж орон нутгийн болон улсын төсөвт тусгуулан шийдвэрлэх.
14. Илгээлтийн эзэн-Анхдагчдын нийгмийн баталгааг сайжруулахад онцгой анхаарал тавих.
45-дээш насын иргэдийг ажлын байраар хангах, орлогтой болгоход бүх талын дэмжлэг үзүүлэхэд ан хаарч ажиллана.

МОРИЙН ХӨТӨЛБӨР

БОЛОВСРУУЛСАН:  R. ЦЭРЭНДОРЖ

2020.07.23

